



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын талаарх ерөнхий мэдээлэл	3
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	5
ХОЁР. ТӨСВИЙГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН НОТОЛГОО-ҮР ДҮНД СУУРИЛЖ, ТӨЛӨВЛӨХ НЬ ЗҮЙТЭЙ БАЙНА	7
ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ ХЭТ ӨНДӨР ТӨСӨӨЛСӨН НЬ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА	11
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД НИЙТ ЗАРЛАГЫН ДҮНГ ӨМНӨХ ОНООС НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.....	13
ТАВ. ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ТОДОРХОЙ БОЛГОХ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХЭД ЧУХАЛ ҮР НӨЛӨӨ ҮЗҮҮЛНЭ	16
ЗУРГАА. ДҮГНЭЛТ	17
ЗӨВЛӨМЖ:	19
ХАВСРАЛТ	20
<i>Хавсралт 1. Төсвийн үзүүлэлтүүд</i>	20
<i>Хавсралт 2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д заасан төсөвлөлтийн шалгуурт нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт</i>	21
<i>Хавсралт 3. Хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй төсөл, арга хэмжээний жагсаалт</i>	24
<i>Хавсралт 4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжтой төсөл, арга хэмжээ</i>	25



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын их хурал
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Төсвийн үзүүлэлтүүд	20
Хавсралт 2	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д заасан төсөвлөлтийн шалгуурт нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	21-23
Хавсралт 3	Хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	24
Хавсралт 4	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжтой төсөл, арга хэмжээ	25



Аудитын талаарх ерөнхий мэдээлэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 2021 оны А/28 дугаар тушаалын дагуу гүйцэтгэлээ.

Төрийн аудитын эрх зүй, стандартын шинэтгэлийн хүрээнд төрийн аудитын байгууллага төсвийн төсөлд дүгнэлт гаргах бүрэн эрхээ хэрэгжүүлэх бодлого, чиглэлээ шинэчлэн баталгаажуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Аудитын зорилго

Дээрх шинэчлэлийн хүрээнд төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын ерөнхий зарчим, зорилго, хамрах хүрээ, арга хандлага, шалгах зүйл, шалгуур үзүүлэлтийг стандартад нийцсэн, хараат бус байдлыг хангасан үр нөлөө бүхий дүгнэлт, зөвлөмж гаргахыг зорьж ажилласан.

Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах нөөц боломжийг бүрэн дайчилсан эсэх
- Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх оновчтой бодлого, зорилт дэвшүүлсэн эсэх.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817 : 2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Төсөв, санхүү, эдийн засгийн салбарын эрдэмтэн, судлаачдын дунд "Монгол Улсын төсөв - 2022" сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулан, үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж, аудитад ашиглав.

Аудитын хамарсан хүрээ

Аудитын явцад Монгол Улсын нэгдсэн төсөв, шат шатны төсвийн захирагчдын 2020 оны батлагдсан төсөв, 2021 оны батлагдсан төсөв, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл, холбогдох танилцуулга мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн судалгаа, мэдээлэл, төсөвтэй холбоотой цахим систем, хөндлөнгийн шинжээч,



**Талуудын хүлээх
үүрэг, хариуцлага**

**Аудитын
бүрэлдэхүүн**

судлаачдын хийсэн судалгаа, шинжилгээний тайлан зэрэгт үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийв.

Сангийн яам ТЕЗ-дын төсвийн саналыг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын 1 дүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, Аудитын 2, 3, 4 дүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Д.Энхболд, Я.Самбууням нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын удирдлагын менежер Ж.Батсайхан хэрэгжүүлж, Шилэн дансны хяналтын хэлтсийн дарга Д.Отгонбаяр, ахлах аудитор Ц.Өсөхбаяр, Б.Хишигтогтох, Б.Анхбаатар, аудитор Ц.Батсүх, Ц.Цэрэннамжил, А.Баясгалан, Б.Оюу, Н.Ган-Очир, гэрээт ажилтан Б.Мөнхцэцэг нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитад Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг үндэслэн хөндлөнгийн шинжээчийг татан оролцуулсан болно.



НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын 2022 оны макро эдийн засаг ба төсвийн бодлого, төлөвлөлтийн талаар

1.1. Монгол Улсын ДНБ-ий бодит өсөлт 2020 онд -5.3 хувь байсан бол 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.6 хувь болж 2 дахин өсөх төлөвтэй байна. Эдийн засгийн сэргэлтэд түүхий эдийн үнэ 2021 онд дунджаар 20-30 хувийн өсөлттэй байсан нь голлон нөлөөлжээ. Харин 2022 онд түүхий эдийн үнэ харьцангуй буурах хандлагатай ба үүнээс нүүрсний үнэ илүү их буурах төлөвтэй байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөлөл

/ам доллар/

Төрөл	2021.08 сар	Жилийн өсөлтийн хувь	2022 оны төсөөлөл	Жилийн өсөлтийн хувь
Зэс	9,197.0	48.0	8,915.0	-3.1
Алт	1,803.0	2.0	1,821.0	1.0
Төмрийн хүдэр	184.0	68.0	Буурна	Буурна
Нүүрс	152.0	21.0	130.0-140.0	-11.2
Газрын тос	67.0	55.0	65.0	-3.0

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн танилцуулга

1.2. Олон улсын байгууллагууд болон Монгол Улсын Засгийн газар цар тахлын халдвар буурч, нүүрсний экспорт өснө гэсэн таамаглал дээр үндэслэн эдийн засгийн өсөлтийг тооцоолжээ. Иймд Монгол Улс нийтийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлж, цар тахлын халдварыг бууруулснаар гадаад худалдаа, нүүрсний экспорт саадгүй явах нөхцөл бүрдэнэ. “Шинэ хэвийн байдал”-д эдийн засгийн өсөлтийг дэмжих, төсвийн орлогыг бүрдүүлэхэд дараах эрсдэл үүсэж болзошгүй байна. Үүнд:

1.2.1. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт хадгалагдахгүй байх, хил гааль дээрх саатал хэвээр үргэлжлэх зэрэг тодорхой бус байдал үүсэж нүүрсний экспортын биет хэмжээ 36.7 сая тоннд хүрэхгүй байх;

1.2.2. Уул уурхай, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарууд өсөлттэй байгаа хэдий ч бусад аж үйлдвэрийн салбар агшиж, нийт эрэлт багасах.

1.3. ДНБ-ий хэмжээ болон эдийн засгийн өсөлтийг бодитой тооцох нь төсвийн төлөвлөлт бодитой байх үндэслэл болох ба төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хязгаарыг үндэслэлтэй тогтоож батлах нь төсвийн тогтвортой байдал хангагдах суурь болно.

1.4. Экспортын өсөлт, импортын бууралт зэргээс шалтгаалан гадаад худалдааны тэнцэл харьцангуй ашигтай гарч байгаагаас Монгол Улсын гадаад валютын албан нөөц өсөлттэй, валютын ханш харьцангуй тогтвортой байна. Гэхдээ хил гааль нээгдэж, эдийн засгийн эргэлт сайжрах үед импортын бүтээгдэхүүн нэмэгдэх, валютын эрэлт өсөх зэрэг нь манай улсын төгрөгийн ханшийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж, Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний төлбөр төлөвлөснөөс нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй.

1.5. Инфляц, валютын ханшийн нөлөөллөөс үүдэлтэй төсөвт дарамт учирч болзошгүйг анхаарах нь зүйтэй.

1.6. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 15.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлагын хэмжээг 18.2 их наяд төгрөг буюу 38.8 хувь, төсвийн алдагдлыг 2.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувь байхаар төлөвлөжээ. /Хавсралт 1/



1.7. УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөл, танилцуулга, аудитын явцад цуглуулсан баримт нотолгоонд үндэслэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, түүний үндэслэл, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаарх аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг дараах бүлгүүдэд тусгав.



ХОЁР. ТӨСВИЙГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН НОТОЛГОО-ҮР ДҮНД СУУРИЛЖ, ТӨЛӨВЛӨХ НЬ ЗҮЙТЭЙ БАЙНА

2.1. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж төлөвлөсөн эсэхэд дараах дүгнэлтийг өгч байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан эсэх

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Төсвийн төсөлд тусгасан байдал	Тусгай шаардлага хангасан байдал
1	6 дугаар зүйл: 6.1.1. “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх”	2021 оны 05 сарын 06-ны хуулиар Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн байдлаар тооцож баталсан байна.	6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.
2	6 дугаар зүйл: 6.1.2. “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх”	Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 15,771.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлага 18,158.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.8 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2,387.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэж байна.	6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.
3	6.1.3. тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;	2022 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 15.3% байгаа нь сүүлийн 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 17.9%-аас бага байгаа тул тусгай шаардлагыг хангаж байна.	6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.
4	6 дугаар зүйл: 6.1.4. “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх”, 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 6.1.4-т ... 2020 онд ДНБ-ий 70 хувиас, 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас...”	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.4-т зааснаар Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэж заасан боловч 2021 оны 7 сарын 7-нд нэмэлт өөрчлөлт оруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 19 дүгээр зүйл 19.3. Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх гэсэн заалтын дагуу 2022 онд 70 хувиас хэтрэхгүй байх болсон байна. 2021 оны 09 сарын 30-нд Сангийн Яамнаас боловсруулсан Монгол Улсын 2022 оны төсвийн төслийг өргөн мэдүүлсэн баримт бичигт Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь нь 67.2 байх тул тусгай шаардлагыг хангасан байна.	2021 оны 7 сарын 7-нд нэмэлт өөрчлөлт оруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-ын дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь нь 67.2 байх тул тусгай шаардлагыг хангасан байна.



Эх сурвалж: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

2.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд баталж мөрдүүлснээс хойш 11 удаа төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан боловч 2015 оны Төсвийн тухай хуулиас бусад тохиолдолд жилийн төсвийн төслийг төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх бус төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсөвтөө тааруулан өөрчилж ирсэн байна. /Хүснэгт 3/

Хүснэгт 3. Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилсөн байдал

Төсвийн жил	Төсвийн хүрээний мэдэгдэл баталсан огноо	Төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан огноо	Жилийн төсвийг баталсан огноо
2012	2011.07.09	2011.11.30	2011.11.30
2013	2012.05.22	2012.10.25	2012.11.08 /2013.10.25/
2014	2013.05.24	2013.11.14 /2014.05.23/	2013.11.15 /2014.05.23; 2014.12.18/
2015	2014.05.30	2015.01.23 /2015.10.30/	2014.11.14 /2015.01.23; 2015.10.30/
2016	2015.05.21	2015.11.13 /2016.09.09/	2015.11.13 /2016.09.09/
2017	2016.11.10	2017.04.14 /2017.10.26/	2016.11.10 /2017.04.14; 2017.10.26/
2018	2017.05.31	2017.11.14	2017.11.14
2019	2018.05.25	2018.11.02	2018.11.02
2020	2019.05.30	2019.11.13 /2020.08.28/	2019.11.13 /2020.08.28/
2021	2020.08.28	2020.11.13 /2021.07.07/	2020.11.13 /2021.07.07/
2022	2021.05.06	Хуулийн төсөл өргөн барьсан /2021.10.01/	-

2.3. Засгийн газар 2016 оны 6 дугаар сараас хойш Засгийн газрын өрийн баталгаа шинээр гаргаагүй. Мөн 2022 онд өрийн баталгаа гаргахгүй гэж төлөвлөсөн нь Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт Засгийн газрын өрийн баталгааны хэмжээг 2018 оноос нэмэгдүүлэхгүй байх бодлогыг баримтална гэсэнтэй нийцэж байна.

2.4. Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт 3,099.6 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөрт нийт 959.3 тэрбум төгрөг нийт 4,058.9 тэрбум төгрөг төлөхөөр төлөвлөсөн байна. Энэ нь Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн $\frac{1}{4}$ буюу 25.7 хувийг эзэлж байна. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,387.1 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна.

2.5. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд ТЕЗ-дын хэрэгжүүлэх зарим хөтөлбөр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д **“хөтөлбөр гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг”** гэж заасантай бүрэн нийцээгүй, харьяа агентлаг тус бүрээр бүлэглэсэн, арга хэмжээний¹ шинж чанартай байна.

¹ Төсвийн тухай хуулийн 4.1.17. “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;



2.6. ТЕЗ-дын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдаа муутай, үр дүнгийн үзүүлэлтүүд нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан шалгуур үзүүлэлтэд бүрэн чиглээгүй байна.

2.7. Төсвийн төсөл боловсруулахад ТЕЗ-дын бодлого төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан газар, нэгжийн оролцоо хангалтгүйгээс тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт салбарын үйл ажиллагааны үр дүнг бүрэн, бодитой илэрхийлэхгүй байна.

2.8. Төсвийн төслийн танилцуулгад дараах зүйлийг бүрэн тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2² -д заасантай нийцээгүй байна. Үүнд:

- Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, объект, үнийн дүнгээр/;
- ТЕЗ бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга.

2.9. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах” чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас төсвийн төсөл хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцэж буй эсэхийг харьцуулж, үнэлж, дүгнэхэд хүндрэлтэй байна.

2.10. Үндэсний хөгжлийн газраас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3³-т заасны дагуу гаргасан зөвшөөрлийн үндэслэл, холбогдох судалгаа, тооцооллын талаар аудитын багт ирүүлсэн тодруулгад “Төсвийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай 83 хувь, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 71 хувь, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй 69 хувь, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөтэй 40 хувь тус тус уялдаж байна” гэсэн боловч зөвхөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад үндэслэсэн байх бөгөөд цаашид дараах асуудлыг анхаарах шаардлагатай байгаа талаар тусгажээ. Тухайлбал:

- Сангийн яамнаас 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн материалд улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх арга хэмжээ, “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг ирүүлээгүй бөгөөд нэмэлтээр авах шаардлага үүсэж, цаг хугацаа алдсан тул холбогдох судалгаа, тооцоолол, төсвийн задаргааг албан хэрэгцээнд бичгээр болон файлаар ирүүлэх,
- Үндэсний хөгжлийн газрын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжит хугацааг тооцож, хуулийн хугацаанд тулгаж ирүүлэхгүй байх.

2.11. Төсвийн тодотгол хийхдээ ТЕЗ-дын тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд өөрчлөлт оруулж байгаагүй нь төсвийн зарлага хөтөлбөрийн үр дүнтэй бүрэн уялдаагүйг харуулж байна.

³ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.3 макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх



2.12. Сангийн яам НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр БШУС, БОАЖС, ЭМС, ХНХС-ын 2022 оны төсвийн төслийг “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн, нотолгоо-үр дүнд суурилсан байдлаар төлөвлөж эхэлсэн, “Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт”-ийг “*үе шаттайгаар нэвтрүүлэхийг зорьж*”⁴ байгаа нь сайшаалтай байна.

2.13. Дээрх ТЕЗ - дын төсвийн төсөлд тусгасан хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан хүрэх түвшинтэй харьцуулж үзэхэд дараах зорилтуудыг тусгаагүй байна. Тухайлбал:

- БОАЖЯ - Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI, Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь, Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь;
- БШУЯ - Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр), Цэцэрлэгийн бүлэг, бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо;
- ЭМЯ - 10,000 хүн амд ногдох вирус гепатитын өвчлөл.

2.14. Төсвийн төсөлд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг санхүүжих дүнгийн хамт тусгасан хэдий ч ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр⁵, хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд гадаадын зээл, тусламжийн санхүүжилт, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг хамруулж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

2.15. “Олон хэмжээст ядуурлын үзүүлэлт” (MPI) хөгжиж буй орнуудын түвшнээс бага байгаад төсвийн бодлогыг чиглүүлж, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо-үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, арга барилыг сайжруулж, урсгал болон хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн үйл явцыг бүрэн уялдуулах шаардлагатай байна. /Дүрслэл 1/



Эх сурвалж. НҮБ Хүний хөгжлийн үзүүлэлтүүд:
Монгол Улс

⁴ Төсвийн төслийн танилцуулгын 5.8. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (128-р хуудас)

⁵ 4.1.16. “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;

4.1.5. “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;



ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫГ ХЭТ ӨНДӨР ТӨСӨӨЛСӨН НЬ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА

3.1. Монгол Улсын Засгийн газар 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа дараах багц бодлого, зорилт дэвшүүлж, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ гэж тооцжээ.

- Хилээр нэвтрүүлэх хугацааг бууруулах замаар гадаад худалдааг хөнгөвчлөх;
- Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, бүтцийн өөрчлөлт, ногдол ашгийн бодлогыг шинэчлэх;
- Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татварын суурийг өргөжүүлэх.

3.2. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх дээрх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх арга зам, нарийвчилсан тооцоолол тодорхойгүй, салбар хоорондын харилцан уялдаа хангалтгүй байгаа нь төсвийн орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна.

Зарим импортын бараанд онцгой албан татвар ногдуулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нийгэмд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах боломж байна

3.3. Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу “бүх төрлийн тамхи”-д онцгой албан татвар ногдуулахдаа биет нэгжийг “янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхины хувьд 100 ширхэг” гэж тодорхойлжээ.

3.4. Үйлдвэрлэгчийн тодорхойлсон бүтээгдэхүүний танилцуулгад 1500 - 2500 сорох хэмжээтэй гэсэн 1.3 -1.7 мл шингэн бүхий электрон тамхинд татвар ногдуулах биет нэгжийг хэрхэн тодорхойлох, хэдэн ширхэг янжуур тамхитай дүйцүүлэх нь тодорхойгүй, эрх зүйн зохицуулалтгүйгээс 2020 - 2021 онд импортолсон 822.7 мянган ширхэг электрон тамхинд онцгой албан татвар ногдуулаагүй байна.

3.5. Электрон тамхинд онцгой албан татвар ногдуулж буй байдалд хийсэн судалгаагаар улс орнууд шингэний хэмжээ буюу миллилитр, агуулагдах никотины тун зэргээс хамааруулан татвар ногдуулж байна⁶.

3.6. 2022 оны төсвийн төслийг дагалдуулан газрын тосны бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан импортолсон газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд ногдуулах онцгой албан татварыг чөлөөлөх хуулийн төслийг өргөн мэдүүлжээ. Энэ нь Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн 4.3.2 болон 5.2 дахь заалтад тусгасан стандартад нийцээгүй, чанарын шаардлага хангахгүй шатахууныг импортлох, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох зорилтод нийцээгүй байсан.

3.7. Засгийн газраас өргөн мэдүүлсэн уг хуулийн төслөө 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар буцаан татахаар шийдвэрлэсэн тул газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд ногдуулах онцгой албан татварыг тооцоолж төсөвт тусгах шаардлагатай.

⁶ Аудитын багийн тооцооллоор 1 ширхэг электрон тамхийг 40 ширхэг буюу 2 хайрцаг янжуур тамхитай дүйцүүлэн үзэхэд 1.4 тэрбум төгрөгийн онцгой албан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх боломжтой байжээ. Түүнчлэн өсвөр насны хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах, электрон тамхины хэрэглээ, импортыг хязгаарлах ач холбогдолтой юм.



Төрийн захиргааны байгууллагуудын зарим автомашиныг худалдаж, төсвийн орлого нэмэгдүүлэх боломж байна

3.8. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасан шаардлагад нийцээгүй 13 яаманд харьяалах 98, 32 агентлагт хамаарах 248, нийт 346 суудлын автомашиныг худалдан борлуулах замаар төсвийн орлого нэмэгдүүлэх боломж байна.

3.9. Төрийн байгууллагуудын суудлын автомашины ашиглалт, хөрөнгийн зарцуулалт тогтоосон норм хэмжээнээс их хэмжээгээр хэтэрдэг, суудлын автомашин хэрэглэх эрхгүй төрийн албан хаагчид автомашин хэрэглэх явдал яам, агентлаг, бусад төрийн байгууллагад хавтгайрч, төсвийн үргүй зардал нэмэгдсэнийг төрийн аудитын байгууллагын холбогдох аудитаар дүгнэж байсан.

3.10. Дээрх 346 автомашинаас эрсдэл өндөртэй 119 автомашиныг түүвэрлэн авч үзэхэд 2020 онд шатахууны зардалд 361.6 сая, сэлбэг, тос, бусад зардалд 271.6 сая, дулаан зогсоолын зардалд 69.9 сая, жолоочийн цалинд 1,084.1 сая нийт 1,787.2 сая төгрөг зарцуулсан тооцоо гарч байна.

Төрийн нэрийн өмнөөс зохицуулах чиг үүрэг хүлээдэг зарим байгууллагын орлого, зарлагын төлөвлөлтийг төсвийн бүрэлдэхүүнд тусгахгүй байна

3.11. Зохицуулах чиг үүрэг бүхий, өөрийн орлогоос санхүүждэг⁷ байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн салбарын хуулиар тогтоосон байдаг бөгөөд жилийн үйл ажиллагааны төсвийг өөрсдөө баталж, зарцуулдаг зохицуулалттай байна.

3.12. Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна” гэсэн заалтын дагуу дээрх байгууллагын үйл ажиллагааны орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүнд оруулж төлөвлөх нь зүйтэй.

Төсвийн төлөвлөлттэй холбоотой үйл явцыг цахимжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

3.13. Төсвийн тухай хуульд заасан шат шатны төсвийн захирагч нарын төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, Монгол Улсын жилийн төсвийн төслийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажиллагаа нь өргөн цар хүрээтэй, улс орны тогтвортой хөгжилд нөлөө бүхий үйл явц юм.

3.14. Төсвийг төлөвлөх, шат шатанд өргөн мэдүүлэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг цахим болгосноор төсвийн мэдээллийн ил тод, найдвартай байдал нэмэгдэж, хяналт сайжрах, цаг хугацаа хэмнэх, оролцоог хангах ач холбогдолтой юм.

⁷ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бусад төрийн байгууллагатай ижил “төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн хариуцлагын хэлбэртэй бүртгэгдсэн.



ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД НИЙТ ЗАРЛАГЫН ДҮНГ ӨМНӨХ ОНООС НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

4.1. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 18,158.8 тэрбум төгрөгөөр тусгаж, 2021 оны төсвөөс 2,410.5 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар нэмэгдүүлж төсөвлөсөн байна.

4.2. Тус оны нэгдсэн төсвийн зарлагын дээрх өсөлтийг ангиллаар нь авч үзвэл урсгал зардлыг 323.6 тэрбум, хөрөнгийн зардлыг 1,752.6 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 334.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

4.3. Төсвийн төсөлд бүх шатны төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимд ажиллах бодлого чиглэлийг тодорхойлсны дагуу улсын төсвийн урсгал зардлыг нийт дүнгээр 8,362.2 тэрбум төгрөгөөр төсөвлөж, өнгөрсөн оноос 1,894.8 тэрбум төгрөгөөр бууруулсан нь нэг удаагийн шинжтэй нийгмийн халамжийн зардлыг 2,452.0 тэрбум төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

4.4. Төсвийн төсөлд төр зарим үйлчилгээг хувийн хэвшлээс худалдан авах бөгөөд төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, харуул хамгаалалт, хоол үйлдвэрлэл, автомашины үйлчилгээ зэргийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зорилт арга хэмжээг төлөвлөжээ. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг өмнөх оноос 76.1 тэрбум төгрөгөөр буюу 10.9 хувиар нэмэгдүүлсэн байна.

4.5. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн нийт зардлын 93.6 хувь буюу 652.2 тэрбум төгрөгийн зардлыг “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэсэн ерөнхий нэршлээр төсвийн төсөлд тусгаж тухайн зардлаас хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний нарийвчилсан судалгаа, тооцоолол тодорхойгүй байгаа нь төсвийн хяналт сулрах, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна.

4.6. Төсвийн төсөлд 2 яам, 4 агентлагийг 2022 онд шинээр байгуулах, тэдгээрийн урсгал зарлагад нийт 41.6 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Гэтэл эдгээр байгууллагууд хэзээ байгуулагдах нь тодорхойгүй, бүтэц, орон тоо, чиг үүргийг тогтоосон эрх зүйн баримт бичиг батлагдаагүй байна. /Хүснэгт 4/

**Хүснэгт 4. Шинээр байгуулахаар
төсөвлөсөн яам, агентлагийн зардал**
/тэрбум төгрөг/

4.7. Шинээр байгуулах яам, агентлагийн чиг үүргийг одоо хэрэгжүүлж байгаа байгууллагуудын төсөвтэй уялдуулан, давхардах орон тоо, урсгал зарлагыг судалгаанд үндэслэн дахин тооцоолж, зардал бууруулах боломж байна.

№	Байгууллагын нэр	Дүн
1	Хөгжлийн сайд	4.4
2	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	1.9
3	И-Монгол Академи	7.8
4	Сахилгын хороо	1.5
5	Ойн судалгаа, хөгжлийн агентлаг	12.5
6	Боловсролын ерөнхий газар	13.5
Нийт		41.6

4.8. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлээр санхүүжүүлэх бодлого, чиглэлийг тусгасан бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангийн зардалд нийт 1,358.4 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

4.9. Төсвийн төсөлд 2022 оноос жил бүр иргэдээ урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг эхлүүлэх чиглэлийг тусгасан хэдий ч тухайн зардлын үндэслэл бүхий дэлгэрэнгүй тооцоолол, судалгааг гаргаагүй байна.



4.10. Төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 18,158.8 тэрбум төгрөг байхаар төсөвлөснөөс 8.1 хувь буюу 1,461.7 тэрбум төгрөгийг “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрт тусгаж, Ирээдүйн өв сангийн орлогын гол эх үүсвэрийг АМНАТ-ийн орлогоос 1,057.2 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос 404.5 тэрбум төгрөг байхаар тооцжээ.

4.11. Нийгмийн халамжийн шинжтэй “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг Ирээдүйн өв сангаас санхүүжүүлэхээр төсөвлөсөн нь санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцэхгүй байх эрсдэлтэй байна.

4.12. Төсвийн төсөлд 24 ТЕЗ-ийн төсвийн багцад нийт 5,943.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1335 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2022 онд санхүүжүүлэх дүнг 2,137.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнээс 52.6 хувь буюу 702 төсөл, арга хэмжээ өмнөх оноос шилжих, 47.4 хувь буюу 633 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлж эхлүүлэхээр тусгажээ.

4.13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем ашиглан төсвийн төслийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийг бэлтгэсэн хэдий ч Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийг баримтлахгүйгээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй 63 төсөл, арга хэмжээг тусгажээ.

Төсөл, арга хэмжээний тоо, хувь		
эхлэх он	тоо	хувь
2010	5	0.4
2011	5	0.4
2012	5	0.4
2013	6	0.4
2014	5	0.4
2015	1	0.1
2016	2	0.1
2017	1	0.1
2018	69	5.2
2019	150	11.2
2020	210	15.7
2021	243	18.2
2022	633	47.4
Нийт	1335	100.0

4.14. Төсвийн төсөлд тусгасан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, сонгох, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу 2021 оны 4 сарын 1-нээс эхлэн 16 шалгуур үзүүлэлтээр цахим системд төлөвлөн, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж тооцоолсон байна.

4.15. Төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг Төсвийн тухай хуульд заасан холбогдох шалгуурын дагуу тулган баталгаажуулж, дүн шинжилгээ хийхэд дараах үзүүлэлттэй байна. /Хүснэгт 5/

Хүснэгт 5. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ

/тэрбум төгрөг/

№	Төсвийн тухай хуулийн зүйл заалт	Төсөл, арга хэмжээний	
		тоо	мөнгөн дүн
1	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 ⁸ -д нийцээгүй	62	192.7
2	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 ⁹ -д нийцээгүй.	1	3.0

4.16. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан,

⁸ Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэж заасантай нийцээгүй 3.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгажээ.

4.17. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-т заасан “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” шалгуурыг хангаагүй 192.7 тэрбум төгрөгийн санхүүжилт төсөвлөсөн 62 төсөл, арга хэмжээ байна. Иймд эдгээр төсөл, арга хэмжээг нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор дахин эрэмбэлж зайлшгүй хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн зохицуулалт хийх нь зүйтэй. /Хавсралт 2/

4.18. Төсвийн төсөлд тооцоо судалгаагүйгээр “улсын хэмжээнд” гэсэн ерөнхий нэршлээр 178.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан нь төсвийн ил тод байдлыг хангаагүй байна.

4.19. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т “Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд: 4.2.3.Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” гэж заасан.

4.20. Гэтэл нийтийн эзэмшлийн орон сууцны байрны засвар, тохижилтын 12.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээ /Хавсралт 3/, гадна талбайн тохижилтын 36.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл, арга хэмжээг /Хавсралт 4/ тус тус төсөвлөсөн байна. Энэ нь хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчимд нийцэхгүй байна.



ТАВ. ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ТОДОРХОЙ БОЛГОХ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХЭД ЧУХАЛ ҮР НӨЛӨӨ ҮЗҮҮЛНЭ

5.1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хуулийн төслүүдэд туссан эрүүл мэндийн үйлчилгээ, арга хэмжээд төлөвлөсөн хөрөнгийг цар тахлын нөхцөл байдлаас өмнөх 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулж, дүн шинжилгээ хийлээ.

5.2. 2019 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилт 642.5 тэрбум төгрөг, төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 83.8 тэрбум төгрөг буюу нийтдээ 726.3 тэрбум төгрөг байсан зардлыг 2022 оны төсвийн төсөлд хамтад нь 704.1 тэрбум төгрөг болгон 22.2 тэрбум төгрөгөөр буюу 3.1 хувиар бууруулсан байна.

5.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн төсөлд “Эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж үйлчилгээний санхүүжилт”-ийг 2019 оны гүйцэтгэлээс 1,130.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний 704.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хариуцаж, үлдэх 426.3 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлээр санхүүжүүлэхээр төсөвлөсөн.

5.4. Хэрэв уг 426.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэх эрүүл мэндийн даатгалын сангийн орлого дутвал эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын хэмжээ 2019 оны гүйцэтгэлтэй ижил хэмжээнд буюу цар тахлын нөхцөл байдлаас өмнөх түвшинд эргэн очих нөхцөл үүсэхээр байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2022 оны төсөл	Өсөлт	
			Дүн	Хувь
Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	123.4	335.9	212.5	172
Ажиллагсдаас төлөх шимтгэл	150.4	348.4	198.1	132
Бусад даатгуулагчаас төлөх	14.8	34.4	20.0	133
Дүн			430.2	

5.5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгчийн тоо 219.5 мянгаар буурсан, шимтгэлийн хувь хэмжээ хэвээр байхад 430.2 тэрбум төгрөгийн орлогын өсөлтийг тооцсон нь үндэслэл муутай байна. /Хүснэгт 7/

Хүснэгт 7. Шимтгэл төлөгчийн төрөл, тоо

/мянган хүн/

Төрөл	Тоо		Зөрүү
	2019-12-31	2021-9-31	
Аж ахуйн нэгж, байгууллагын	699.7	643.0	- 57.0
Төсөвт байгууллагын	282.3	271.2	- 11.1
Сайн дураар	335.4	184.0	- 151.4
Дүн			- 219.5

Эх сурвалж. ЭМД-ын хамралтын мэдээ 2019, ЭМД-д хамрагдсан даатгуулагчийн мэдээ 2021-09 сар

5.6. Олон улсын байгууллагуудын өгсөн зөвлөмжийн хүрээнд нийтийн эрүүл мэндэд чиглэсэн цогц арга хэмжээнд зайлшгүй зарцуулах хөрөнгийг төсөвт тусгаснаар нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах боломжийг бүрдүүлнэ.



ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

6.1. Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 15,771.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлага 18,158.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.8 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2,387.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэж байгаа нь төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.

6.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2010 онд баталж мөрдүүлснээс хойш 11 удаа төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас нэгээс бусад жилд нь төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсөвтөө тааруулан өөрчилж ирсэн байна.

6.2. Төсвийн тодотгол хийхдээ ТЕЗ -дын тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд өөрчлөлт оруулдаггүй нь төсвийн зарлага хөтөлбөрийн үр дүнтэй бүрэн уялдаагүйг харуулж байна.

6.3. Дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо-үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, арга барилыг сайжруулж, урсгал болон хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн үйл явцыг бүрэн уялдуулах шаардлагатай байна.

6.4. Хууль, эрх зүйн тодорхой зохицуулалтгүйгээс онцгой албан татварыг электрон тамхинд ногдуулах боломжгүй байна.

6.5. Засгийн газраас өргөн мэдүүлсэн газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосиныг онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар буцаан татсан тул уг бараанд ногдуулах онцгой албан татварыг тооцоолж төсөвт тусгах шаардлагатай.

6.6. Засгийн газраас дэвшүүлсэн төсвийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн төрийн захиргааны байгууллагуудын автомашины хэрэглээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна.

6.7. Төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, дүгнэлт гаргах, батлах үйл ажиллагаанд оролцож буй бүх шатны байгууллагууд төсвийн төсөлд тусгагдсан орлого, зардалтай холбоотой нарийвчилсан тоон мэдээлэлтэй нээлттэй танилцах төсвийг оновчтой төлөвлөх, дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдаж байна.

6.8. Үйл ажиллагааны орлогоо өөрөө бүрдүүлж зарцуулдаг, төрийн нэрийн өмнөөс зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагуудын эрх зүйн орчин Төсвийн тухай хуулийн үндсэн зарчимд нийцэхгүй байна.

6.9. АМНАТ-ийн болон хувьцааны ногдол ашгийн орлогыг өөдрөг төсөвлөсөн нь “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байна.

6.10. Төсөвлөлтийн зарим шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын 62 төсөл, арга хэмжээг нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор дахин эрэмбэлж хуулийн шаардлагад нийцүүлэн зохицуулалт хийх шаардлагатай.

6.11. Төсвийн төсөлд “улсын хэмжээнд” гэсэн ерөнхий нэршлээр 178.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан нь төсвийн ил тод байдлыг хангаагүй байна.



6.12. Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны засвар, тохижилтын 19 төсөл, арга хэмжээнд төсөвлөсөн нь, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй байна.

6.13. Олон улсын байгууллагуудаас цар тахлын нөхцөл байдлыг харгалзан өгсөн зөвлөмжийн хүрээнд нийтийн эрүүл мэндэд чиглэсэн цогц арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөвт бодитой тооцож тусгаснаар нүүрсний экспортыг төлөвлөсөн хэмжээнд хүргэж, эдийн засгийн өсөлтийг хангах боломж байна.



УИХ-д толилуулах нь:

1. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, электрон тамхинд албан татвар ногдуулах нөхцөл бүрдүүлэх.
2. Газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосинд ногдуулах онцгой албан татварыг тооцоолж төсөвт тусгах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмж өгч байна.Үүнд:

Засгийн газарт:

1. Төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн төсөлд нийцүүлэн өөрчлөхгүй байх, хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо-үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлж ажиллах.
2. Засгийн газар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж, илүүдэл автомашиныг шилжүүлэх, худалдах замаар үргүй зардлыг бууруулах.
3. Монгол Улсын жилийн төсвийн төслийг боловсруулахдаа үйл ажиллагааны орлогоо өөрөө бүрдүүлж, зарцуулдаг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын эрх зүйн орчинг Төсвийн тухай хуулийн үндсэн зарчимд нийцүүлэх.
4. Хөрөнгө оруулалтын бус шинжтэй нийтийн эзэмшлийн орон сууцны байрны засвар, гадна талбайн тохижилтын ажлыг хууль тогтоомжийн хүрээнд төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, тухайн шатны орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөх.
5. Төсвийн төлөвлөлттэй холбоотой программ хангамжуудыг хөгжүүлэх, уялдааг хангах замаар төсвийг төлөвлөх, шат шатанд өргөн мэдүүлэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах.



ХАВСРАЛТ

Хаавсралт 1. Төсвийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Төсвийн гүйцэтгэл			Төсвийн хүрээний мэдэгдэл			Төсвийн төсөл	
	2018	2019	2020	2020	2021	2022	2022	2023
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.2	5.2	-5.3	6.0	6.5	4.6	5.0	5.0
Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.1	5.2	2.3	8.0	7.2	6.0	6.7	6.0
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	10,172.8	12,040.3	10,444.1	11,797.8	12,056.4	13,206.4	15,771.7	17,168.9
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.4	32.3	28.3	29.0	28.6	28.9	33.7	33.0
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	9,317.2	11,661.7	13,904.3	13,872.6	15,748.3	14,852.0	18,158.8	19,040.7
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	28.7	31.3	37.6	34.1	37.4	32.5	38.8	36.6
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	299.9	2,344.5	2,242.6	2,283.5	1,844.0	900.4	2,410.5	881.9
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.9	6.3	6.1	5.6	4.4	2.0	5.2	1.7
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	27.9	(756.2)	(4,440.5)	(2,074.7)	-3,691.8	-1,645.6	(2,387.1)	(1,871.9)
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	0.1	-2.0	-12.0	-5.1	-8.8	-3.6	-5.1	-3.6
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,680.4	3,016.7	3,034.2	3,678.9	3,363.5	3,768.9	5,116.1	5,569.3
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.2	8.1	8.2	9.0	8	8.2	10.9	10.7
Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	18,955.9	20,525.6	23,024.3	22,089.1	25,818.4	27,073.7	31,439.4	32,727.2
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	58	55	62	54	61.3	59.2	67	63
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/				756.6	2,994.7	851.3	490.4	530.0
-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь				1.9	7.1	1.9	1.0	1.0



Хавсралт 2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д заасан төсөвлөлтийн шалгуурт нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/тэрбум төгрөг/

№	Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хувь хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа
1	III.1.1.47	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2022	2024	11.9	2.0	20-с доош	3 он дамжих
2	III.1.1.48	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга, 1000 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	2022	2024	13.0	2.0	20-с доош	3 он дамжих
3	IV.1.1.1	"Алтанбулаг" чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2022	2024	15.6	1.0	20-с доош	3 он дамжих
4	XI.5.1.9	Ахмадын амралт, сувиллын цогцолборын өвлийн байрны өргөтгөл /Хөвсгөл, Хатгал сум/	2022	2024	2.0	0.5	20-25 хувь	3 он дамжих
5	XII.1.84	Аймгийн төвийн 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээ /Дорнод, Хэрлэн сум/	2022	2024	9.8	1.0	20-с доош	3 он дамжих
6	XII.1.87	Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/	2022	2024	100.0	26.0	25-30 хувь	3 он дамжих
7	XII.1.92	Буянт Ухаа-2 хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар ээлжийн ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2022	2024	2.1	0.5	20-25 хувь	3 он дамжих
8	XII.1.95	Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт /Говь-Алтай, Есөнбулаг сум, Баянхайрхан баг/	2022	2024	1.8	0.2	20-с доош	3 он дамжих
9	XII.1.97	Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт /Говь-Алтай, Есөнбулаг сум, Харзат баг/	2022	2024	1.2	0.2	20-с доош	3 он дамжих
10	XII.1.122	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	2022	2024	2.5	0.2	20-с доош	3 он дамжих
11	XII.1.123	Сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга /Говь-Алтай, Халиун сум/	2022	2024	2.4	0.2	20-с доош	3 он дамжих
12	XII.1.127	Сумын ундны усан хангамжийн дэд бүтэц /Говь-Алтай, Халиун сум/	2022	2024	2.6	0.2	20-с доош	3 он дамжих
13	XII.1.129	Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт /Төв, Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур сум/	2022	2024	16.0	3.5	20-25 хувь	3 он дамжих
14	XII.1.134	Үерийн хамгаалалтын байгууламж, С-3, 4 /Булган аймаг, Хутаг-Өндөр сум/	2022	2024	4.4	1.0	20-25 хувь	3 он дамжих
15	XII.1.135	Үерийн хамгаалалтын барилга байгууламж /Сэлэнгэ, Сант сум, Ивэн голын боомт/	2022	2024	3.2	0.6	20-25 хувь	3 он дамжих
16	XII.1.144	Хотын гэрэлтүүлэг /Дархан-Уул, Дархан сум/	2022	2024	12.0	3.0	20-25 хувь	3 он дамжих
17	XII.1.148	Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, 1.5 км /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2022	2024	2.4	0.2	20-с доош	3 он дамжих
18	XIII.1.1.244	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/	2022	2024	5.2	1.0	20-25 хувь	3 он дамжих



19	XIII.1.1.250	Дотуур байрны барилга, 100 ор /Баян-Өлгий, Алтанцөгц сум/	2022	2024	2.9	0.7	20-25 хувь	3 он дамжих
20	XIII.1.1.256	Дотуур байрны барилга, 100 ор /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	2022	2024	2.9	0.2	20-с доош	3 он дамжих
21	XIII.1.1.258	Дотуур байрны барилга, 150 ор /Булган, Хутаг-Өндөр сум/	2022	2024	3.2	0.8	20-25 хувь	3 он дамжих
22	XIII.1.1.259	Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан, Төгрөг сум, Гол баг/	2022	2024	3.3	0.8	20-25 хувь	3 он дамжих
23	XIII.1.1.274	Сургуулийн барилга, 320 суудал /Дорноговь, Хатанбулаг сум, 5 дугаар баг/	2022	2024	7.9	2.0	25-30 хувь	3 он дамжих
24	XIII.1.1.275	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Улаангом, 10 дугаар баг Улиасны хэв/	2022	2024	7.5	1.0	20-с доош	3 он дамжих
25	XIII.1.1.278	Сургуулийн барилга, 640 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	2022	2024	9.5	2.0	20-25 хувь	3 он дамжих
26	XIII.1.1.279	Сургуулийн барилга, 640 суудал /Завхан, Улиастай сум, 5 дугаар баг/	2022	2024	8.2	1.5	20-с доош	3 он дамжих
27	XIII.1.1.281	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Дундговь, Эрдэнэдалай сум/	2022	2024	9.5	2.0	20-25 хувь	3 он дамжих
28	XIII.1.1.282	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Олимп хотхон/	2022	2024	10.2	2.0	20-25 хувь	3 он дамжих
29	XIII.1.1.283	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Галт сум, 5 дугаар баг/	2022	2024	10.1	1.5	20-с доош	3 он дамжих
30	XIII.1.1.284	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Жаргалант сум, 5 дугаар баг/	2022	2024	10.1	1.5	20-с доош	3 он дамжих
31	XIII.1.1.285	Сургуулийн барилга, 960 суудал /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	2022	2024	11.0	1.5	20-с доош	3 он дамжих
32	XIII.1.1.287	Сургуулийн барилга, 960 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн сум, 8 дугаар баг, Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/	2022	2024	9.9	1.5	20-с доош	3 он дамжих
33	XIII.1.1.289	Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/	2022	2024	3.4	0.4	20-с доош	3 он дамжих
34	XIII.1.1.295	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Сэлэнгэ, Цагааннуур сум, 3 дугаар баг/	2022	2024	4.2	1.0	20-25 хувь	3 он дамжих
35	XIII.1.1.296	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн сум, Титэм сургууль/	2022	2024	7.5	1.2	20-с доош	3 он дамжин санхүүжих
36	XIII.1.1.298	Сургуулийн дотуур байрны барилга /Говь-Алтай, Дэлгэр сум, Гуулин тосгон/	2022	2024	2.9	0.2	20-с доош	3 он дамжих
37	XIII.1.1.314	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 280 ор /Булган, Булган сум, 4 дүгээр цэцэрлэг/	2022	2024	4.9	1.0	20-25 хувь	3 он дамжих
38	XIII.1.1.315	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 320 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум, Харзат баг, 6 дугаар цэцэрлэг/	2022	2024	4.3	0.2	20-с доош	3 он дамжих
39	XIII.1.1.331	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо/	2022	2024	3.4	0.5	20-с доош	3 он дамжих
40	XIII.1.1.336	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Мөрөн сум, 7 дугаар цэцэрлэг/	2022	2024	3.8	0.5	20-с доош	3 он дамжих
41	XIII.1.1.337	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр баг/	2022	2024	4.2	1.0	20-25 хувь	3 он дамжих
42	XIII.1.1.340	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо/	2022	2024	4.2	0.5	20-с доош	3 он дамжих
43	XIII.1.1.348	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Говь-Алтай, Чандмань сум/	2022	2024	1.6	0.2	20-с доош	3 он дамжих
44	XIII.1.3.6	Багш хөгжлийн танхимын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2024	2.5	0.6	20-25 хувь	3 он дамжих



45	XIII.1.3.18	Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын тоног төхөөрөмж /Дархан-уул/	2022	2024	2.0	0.2	20-с доош	3 он дамжих
46	XIV.1.66	Соёлын төвийн барилга, 250 суудал /Говь-Алтай, Халиун сум/	2022	2024	2.3	0.2	20-с доош	3 он дамжих
47	XIV.1.67	Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2022	2024	4.4	0.8	20-с доош	3 он дамжих
48	XV.1.1.52	Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/	2022	2024	49.8	10.5	20-25 хувь	3 он дамжих
49	XV.1.1.54	Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/	2022	2025	114.0	25.0	20-25-с хувь	4 он дамжих
50	XV.1.1.56	Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 71 км /Хэнтий, Норовлин сум, Дорнод, Баян-уул сум/	2022	2024	66.7	10.5	20-с доош	3 он дамжих
51	XV.1.1.60	Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 130 км /Хэнтий, Батноров, Норовлин сум/	2022	2025	109.1	25.0	20-25-с хувь	4 он дамжих
52	XV.1.1.75	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	2022	2024	5.4	1.0	20-с доош	3 он дамжих
53	XV.1.1.78	Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/	2022	2025	115.9	25.0	20-25-с хувь	4 он дамжих
54	XV.1.1.84	Хужирт-Бат-Өлзий чиглэлийн хатуу хучилттай авто зам, 49 км /Өвөрхангай/	2022	2025	51.6	11.0	20-25-с хувь	4 он дамжих
55	XVIII.1.39	Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/	2022	2024	4.5	1.0	20-25 хувь	3 он дамжих
56	XIX.1.49	Нийслэлийн 2 дугаар төрөх "Хүрээ амаржих" газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2024	18.0	2.0	20-с доош	3 он дамжих
57	XIX.1.58	Сумын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламж /Улсын хэмжээнд/	2022	2024	24.1	3.0	20-с доош	3 он дамжих
58	XIX.1.60	Эрт илрүүлэг, оношилгооны төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2024	2.8	0.7	25-30 хувь	3 он дамжих
59	XIX.1.62	Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	2022	2024	2.5	0.2	20-с доош	3 он дамжих
60	XIX.1.68	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Хөвсгөл, Арбулаг сум/	2022	2024	1.4	0.2	20-с доош	3 он дамжих
61	XIX.1.77	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2024	17.3	3.9	20-25 хувь	3 он дамжих
62	XIX.2.6	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2024	12.1	3.0	20-25 хувь	3 он дамжих
Нийт 62 төсөл, арга хэмжээ					965.0	192.7		



Хавсралт 3. Хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/тэрбум төгрөг/

№	Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТЕЗ	Ангилал
			Эхлэх	Дуусах				
1	XII.2.22	Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны их засвар, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, 76 байр/	2022	2022	0.8	0.8	БХБС	Их засвар
2	XII.2.23	Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны их засвар, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, 1 дүгээр байр/	2022	2022	1.6	1.6	БХБС	Их засвар
3	XII.2.24	Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны их засвар, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2023	4.0	2.2	БХБС	Их засвар
4	XII.2.25	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 1, 2, 51 дүгээр байр/	2022	2022	1.0	1.0	БХБС	Их засвар
5	XII.2.26	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 2, 30, 31 дүгээр байр/	2022	2022	0.8	0.8	БХБС	Их засвар
6	XII.2.27	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 27, 29 дүгээр хороо/	2022	2023	2.0	0.6	БХБС	Их засвар
7	XII.2.28	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар, гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1, 3, 7, 19, 23 дугаар хороо/	2022	2023	1.6	1.0	БХБС	Их засвар
8	XII.2.29	Нийтийн эзэмшлийн орон сууцны засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, 47/1 дүгээр байр, 4 дүгээр хороо, 4, 5, 6, 7 дугаар байр/	2022	2022	0.5	0.5	БХБС	Их засвар
9	XII.2.30	Нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум/	2022	2023	3.0	1.0	БХБС	Их засвар
10	XII.2.31	Нийтийн эзэмшлийн орон сууцны фасад, тохижилт, засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2022	3.0	3.0	БХБС	Их засвар
Дүн					18.3	12.5		



Хавсралт 4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжтой төсөл, арга хэмжээ

/тэрбум төгрөг/

№	Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүү- жих дүн	ТЕЗ	Ангилал
			Эхлэх	Дуусах				
1	VI.1.16	Дүүргийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2022	5.3	5.3	БОАЖС	Барилга байгууламж
2	XII.1.93	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/	2022	2023	1.0	0.5	БХБС	Барилга байгууламж
3	XII.1.102	Дунд голын тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2023	4.8	2.0	БХБС	Барилга байгууламж
4	XII.1.103	Дүүргийн тохижилт, ногоон байгууламж /Улаанбаатар, Налайх, Багануур дүүрэг/	2022	2022	1.0	1.0	БХБС	Барилга байгууламж
5	XII.1.106	Иргэдэд зориулсан ногоон орчин, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо/	2022	2023	1.0	0.7	БХБС	Барилга байгууламж
6	XII.1.109	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хаягжуулалт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2023	1.0	0.5	БХБС	Барилга байгууламж
7	XII.1.115	Сум, аймгийн төвийн гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Улсын хэмжээнд/	2022	2022	10.0	10.0	БХБС	Барилга байгууламж
8	XII.1.116	Сум, багийн орчныг сайжруулах тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг баг/	2022	2022	1.6	1.6	БХБС	Барилга байгууламж
9	XII.1.124	Сумын төвийн тохижилт /Увс, Зүүнхангай, Ховд, Наранбулаг, Хяргас, Өндөрхангай, Завхан, Малчин сум/	2022	2022	6.9	6.9	БХБС	Барилга байгууламж
10	XII.1.131	Увс, Хяргас нуур орчмын тохижилт /Увс/	2022	2023	2.0	1.0	БХБС	Барилга байгууламж
11	XII.1.140	Хороо, дүүргийн орчныг сайжруулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 19 дүгээр хороо/	2022	2023	2.6	1.0	БХБС	Барилга байгууламж
12	XII.1.141	Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Жишиг гудамж" тохижилтын төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2023	3.0	1.0	БХБС	Барилга байгууламж
13	XII.1.150	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 5, 6, 7, 8, 9 дүгээр хороо/	2022	2022	1.2	1.2	БХБС	Барилга байгууламж
14	XII.1.151	Чингүнжавын гудамжны тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2023	0.9	0.5	БХБС	Барилга байгууламж
15	XII.1.152	Явган хүний зам, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2023	1.5	0.8	БХБС	Барилга байгууламж
16	XII.2.20	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гадна тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 6, 8, 13, 14, 15, 16, 18, 25, 26 дугаар хороо/	2022	2023	0.8	0.5	БХБС	Их засвар
17	XII.2.21	Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар шинэчлэлт, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2023	2.0	1.0	БХБС	Их засвар
18	XII.2.32	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	2023	1.4	0.7	БХБС	Их засвар
19	XV.3.1.4	Хороо, дүүргийн нийтийн тээврийн автобусны буудлын тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2023	0.8	0.5	ЗТХС	Барилга байгууламж
Дүн					48.7	36.5		